



XI/2021


Тархаасан: 2021 оны 12 дугаар сарын 14



Нас гүйцсэн эр хонины үнэ Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 300.0 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 11 дүгээр сард атны үнэ 1.4 сая төгрөг болж, өмнөх сараас 42.4 мянган төгрөгөөр, хязаалан гуных 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 66.3 мянган төгрөгөөр, соёолон үрээнийх 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 32.3 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Эр хонины үнэ 207.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 200 төгрөгөөр, эр ямааны үнэ 148.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.7 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ(сум), 2021 оны 11 дүгээр сард, мянган төгрөгөөр




Эр хонь 2021 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод хамгийн их буюу 300.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 20.0 мянган төгрөгөөр өсөж, харин Дорнод аймагт хамгийн бага буюу 160.7 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.6 мянган төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2021 оны 11 дүгээр сард




Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 11 дүгээр сард боодолтой өвсний (20 кг) үнэ Баянхонгор аймагт хамгийн их буюу 22.0 мянган төгрөг, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 3.6 мянган төгрөг байна.

ЗУРАГ 3. БООДОЛТОЙ ӨВСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, 2021 оны 11 дүгээр сард



Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2021 оны 11 дүгээр сард 5.9 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.1 мянган төгрөгөөр, ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 100.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 10.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 4. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 11 дүгээр сард, төгрөг



Хивэгний (25 кг) үнэ 2021 оны 11 дүгээр сард Хэнтий аймагт хамгийн их буюу 24.0 мянган төгрөг, Архангай аймагт хамгийн бага буюу 13.5 мянган төгрөг байна.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 1 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын дарга
А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн газрын
Үнийн статистикийн хэлтсийн гэрээт
ажилтан Б.Оргил
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212